- 4.2.5 Ахлах ажилтан асгарсан бодисын тархалтыг хязгаарлаж, цэвэрлэх ажиллагааг зохион байгуулна.
Ахлах ажилтан Байгаль орчны нэгжийг асгаралтын талаарх дэлгэрэнгүй мэдээллээр хангаж, шаардлагатай бол заавар зөвлөмж авч ажиллана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Говь-аргатай девелопмент ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2025 оны... сарын
.....өдрийнтоот тушаалын.....хавсралт

- 4.2.6 Асгаралтыг мэдээлэх, судалгаа хийх ба хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаагаа нь “Ослыг судлан бүртгэх болон тайлагнах” журмаар зохицуулагдана.
- 4.2.7 Хатуу хучилттай талбайгаас бусад газар асгарсан 10л-с дээш хэмжээтэй шатахуун, бүх төрлийн тосолгооны материал, 1 м-с дээш хэмжээтэй хаягдал ус, 1л-с дээш хэмжээтэй химийн бодис тус бүрийг тухайн ажлын байрны ахлах ажилтан, менежер ОСОЛ МЭДЭГДЭХ МАЯГТ-р ЭМАА,БО хэлтэсд яаралтай мэдэгдэнэ.
- 4.2.8 Бодис асгарснаас үүдэн гэнэтийн хоёрдогч аюул учирч болзошгүй тохиолдолд (жишээ нь: гал гарах, дэлбэрэх, гүний ус бохирдох гэх зэрэг) тухайн эрсдлийг тогтоосон ажилтан төслийн талбай дахь аврах багт нэн даруй мэдэгдэнэ.
- 4.2.9 Асгаралтын улмаас байгаль орчинд их хэмжээний хохирол учруулсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу компанийн Байгаль орчны нэгж орон нутгийн байгаль орчны албанд мэдэгдэнэ.

Асгаралтын тархалтыг хязгаарлах

- 4.2.10 Асгаралтын цэвэрлэгээг эхлүүлэхээс өмнө асгарсан бодис материал илүү их хэмжээний талбай бохирдуулах болон ус зайлуулах суваг шуудуу, шугам хоолойд орохоос сэргийлж түүний орон зайн тархалтыг хязгаарлах арга хэмжээ авна.
- 4.2.11 Асгарсан бодисын тархалтыг хязгаарлахдаа бодис материал асгарсан талбайг хүрээлэн шингээгч материалаар хашилт хийх ба хэрэв асгаралт гадаад талбайд болсон бол шороон далан байгуулан хязгаарлаж болно.

4.3 Асгаралтыг цэвэрлэх

- 4.3.1 Асгаралтын цэвэрлэгээг зохион байгуулахдаа тухай бүр, хурдан шуурхай ажиллах, бүрэн гүйцэд цэвэрлэх зарчим баримтална.
- 4.3.2 Асгаралтыг цэвэрлэх ажилтан нь тухайн төрлийн асгаралтыг цэвэрлэх хангалттай мэдлэг, ойлголттой байна.

Асгарсан бодисыг цэвэрлэх хэрэгсэл

- 4.3.3 Асгаралт үүсч болзошгүй ажлын байранд асгарсан бодисыг цэвэрлэх хэрэгслийн иж бүрдлийг байрлуулсан байх ба иж бүрдлийн байрлал нь бодис асгарсан тохиолдолд түүнийг саадгүйгээр ашиглах боломжтой газар байна.
- 4.3.4 Асгаралт цэвэрлэх хэрэгслийн иж бүрдлийн байнгын бэлэн байдал, хангалтыг тухайн ажлын байрны ахлах ажилтан хариуцна.
- 4.3.5 Хэлтэс албаны удирдлагууд тухайн жилийн төсөвтөө шаардлагатай асгаралт цэвэрлэх хэрэгслийг худалдан авах зардлыг тооцож, батлуулсан байна.
- 4.3.6 Асгаралт цэвэрлэх хэрэгслийн иж бүрдэлд шингэн бодис материалын зориулалтын шингээгч, хуурай нунтаг, арчих материал, модны үртэс, хүрз, хамгаалалтын резинен бээлий, асгарч буй бодисыг тосох 60 л-ээс багагүй багтаамжтай тагтай сав, аюулгүйн тууз зэрэг багтана.

Нүүрс-устөрөгчийн асгаралт

- 4.3.7 Асгаралтыг хязгаарласны дараа нүүрс-устөрөгчийг шингээгч материалд (зориулалтын шингээгч, модны үртэс, шороо г.м) шингээн авах ба хэрвээ тухайн асгарсан бодис нь дангаараа эсвэл усан дээр хөвж байгаа тохиолдолд түүнийг соруулж авна.
- 4.3.8 Асгаралт гадаад талбайд болсон тохиолдолд тухайн бодис нэвчсэн гүн хүртэл хөрснийг бүрэн хусч ухаж авч цэвэрлэх ба талбайг бохирдоогүй хөрс шороогоор хучна
- 4.3.9 Нүүрс-устөрөгчийг ус зайлуулах хоолой болон усны сувагт нэвтрэхээс онцгойлон

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Говь-аргатай девелопмент ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2025 оны... сарын
.....өдрийнтоот тушаалын.....хавсралт

урьдчилан сэргийлнэ. Хэрэв нүүрс-устөрөгч ус зайлуулах хоолой болон усны сувагт нэвтэрсэн бол нэн даруй түүнийг хөвөгч хүрээгээр тусгаарлаж тархалтыг нь хязгаарлана.

Ахуйн бохир усны асгаралт

- 4.3.10 Асгаралтын тархалтыг бүрэн хязгаарласны дараа асгарсан бохир усыг соруулж авах боломжтой бол бохир усыг сорогч машинаар шавхаж, ус цэвэршүүлэх байгууламжруу хүргүүлнэ.
- 4.3.11 Асгаралт ургамлан бүрхэвчгүй, өнгөн хөрсний давхаргагүй, элэгдэл эвдрэлд орсон талбайд эсвэл зориудаар хучилт хийсэн газар болсон бол цэвэрлэгээний үед гадаргын дээд хэсгийг хуулж авах бөгөөд талбайг гипохлорид натрийн нунтаг, түүний усан уусмал ашиглан ариутгана.
- 4.3.12 Бохир ус асгарсан талбайг ариутгах үйл ажиллагааг“Орчны эрүүл ахуйн” журмаар зохицуулна.
- 4.3.13 Ургамлан бүрхэвчтэй, өнгөн хөрсний давхаргатай гадарга дээр бохир усны асгаралт үүссэн тохиолдолд цэвэрлэгээ ариутгалын үед өнгөн хөрсийг хуулах, гэмтээхээс зайлсхийнэ.

Үйлдвэрийн хаягдал усны асгаралт

- 4.3.14 Умбуур бодисын хэмжээ бага байгаа тохиолдолд тархалтын хязгаарлалт хийгдсэний дараа хаягдлыг өөрөөр нь ууршуулна.
- 4.3.15 Умбуур бодисын хэмжээ их буюу ургамлан бүрхэвч, өнгөн хөрснийг бохирдуулах эрсдэлтэй бол бага даралттай цэвэр усаар угааж зайлуулна.
- 4.3.16 Хаягдал усанд агуулагдах бодис элементийн агууламж холбогдох стандартаас өндөр үзүүлэлттэй байгаа тохиолдолд газрын гадаргын хөрснийг хусч хуулж цэвэрлэх арга хэмжээ авна.

Химийн бодисын асгаралт

- 4.3.17 Асгарсан химийн бодисын шинж чанараас хамааран түүнийг цэвэрлэх аргачлал нь харилцан адилгүй байна.
- 4.3.18 Химийн бодис асгарсан тохиолдолд хордох болон галын аюул гарахаас сэргийлж асгаралт үүссэн талбайг тусгаарлана.
- 4.3.19 Зориулалтын хамгаалалтын хувцас хэрэглэл өмсөхгүйгээр гэмтсэн сав, асгарсан бодисонд хүрэх болон асгарсан материал дундуур явах, хүрэхийг хориглоно.
- 4.3.20 Асгарсан бодисыг зориулалтын сав болон уутанд хийж бодисын нэр, асгарсан огноог бичиж, тухайн бодисын ХАЛМ-д заасны дагуу хадгална.
- 4.3.21 Хэрэв боломжтой бол асгарсан бодисыг дахин ашиглах ба бусад тохиолдолд бодисын хаягдлыг журмын дагуу устгана.
- 4.3.22 Химийн бодисын асгаралтыг цэвэрлэхээс өмнө тухайн бодисын ХАЛМ-тэй таншцаж, тус баримт бичигт тусгагдсан заавар зөвлөмжийг чанд баримтлан ажиллана.
- 4.3.23 Асгарсан бодисын талаар тодорхой мэдлэггүй, хаяг шошго нь тодорхойгүй бол нэн даруй тухайн хэсгийг харуцсан удирдах ажилтанд мэдээлнэ.
- 4.3.24 Тухайн асгарсан химийн бодисыг цэвэрлэх боломжгүй бол асгарсан хэсгийн хил хязгаарыг аюулгүйн туузаар тэмдэглэн, бодис асгарсан гэсэн анхааруулах самбар байрлуулан удирдах ажилтанд нэн яаралтай мэдээлнэ.
- 4.3.25 Их хэмжээний асгаралт үүссэн, тус асгаралт нь онцгой нөхцөл байдалд хүргэж байгаа бол“Онцгой байдлын үед бэлэн байх, харну арга хэмжээ авах” журам болон химийн бодисын онцгой байдлын төлөвлөгөөний дагуу харну арга хэмжээг авч ажиллана.

Хуурай бодис материалын асгаралт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Говь-аргатай девелопмент ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2025 оны... сарын
...өдрийн ...тоот тушаалын...хавсралт

- 4.3.26 Үнс, цемент зэрэг хуурай бодис материал асгарсан тохиолдолд түүнийг хийсч тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлнэ.
- 4.3.27 Асгарсан хуурай бодис материалыг цэвэрлэхдээ газрын гадарга, хөрсийг хөндөж гэмтээхээс зайлсхийнэ.
- 4.4 Бохирдсон хөрсийг саармагжуулах
- 4.4.1 Хэрэв асгаралт ургамлан бүрхэвчтэй, өнгөн хөрс хөндөгдөөгүй газар дээр болсон бол цэвэрлэгээг хийхдээ дээд хэсгийн бохирдсон хөрсийг 30см-с багагүй зузаантайгаар түүний доод давхаргаас ялгаж хуулах ба саармагжуулах зорилгоор тусад нь хадгална.
- 4.4.2 Бохирдсон хөрсийг саармагжуулахдаа нэгдсэн аргачлалыг баримтлах ба саармагжуулах ажлыг хог хаягдлын цэгийн үйл ажиллагааны заавраар зохицуулна.
- 4.5 Бохирдсон материалыг устгах
- 4.5.1 Цэвэрлэгээнээс үүссэн бохирдсон шингээгч, арчих материал зэргийг аюултай хог хаягдлыг ангилан ялгах хогийн саванд хийх ба ОН8Е.ЕК604 Хог хаягдлын удирдлага зохицуулалтын журмын дагуу устгана.
- 4.5.2 Бохирдсон шороог тусгай сав эсвэл үл нэвчүүлэх гадарга дээр түр хадгалах ба журманд зааснаар зохицуулна.
- 4.5.3 Бохирдсон хөрс цуглуулах нэгдсэн цэгийн үйл ажиллагаанд Байгаль орчны нэгж хяналт тавих ба ашиглалтыг хог хаягдлын үйлчилгээ хариуцсан гэрээт компани хариуцна.

ТАВ. БУСАД

Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд компанийн холбогдох дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ЗУРГАА. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Газрын тухай хууль
- Усны тухай хууль
- Газрын хэвлийн тухай хууль
- Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль

ДОЛОО. ХАВСРАЛТ, МАЯГТ

Асгаралт үүсгэж болзошгүй үйл ажиллагааны бүртгэл

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Говь-аргатай девелопмент ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2025 оны... сарын

...өдрийн ...тоот тушаалын...хавсралт

Асгаралт үүсгэж болзошгүй үйл ажиллагааны бүртгэл

№	Алба, хэсгийн нэр	Асгаралт үүсгэж болзошгүй үйл ажиллагааны мэдээлэл	Бодис материалын нэр төрөл	Бодис материалын хэмжээ, м3	Байрлал	Нэмэлт тайлбар

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/32

Сүмбэр сум

Зөвшөөрөл олгох тухай

Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Усны Газар"-ын гаргасан 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн Е-2508-000045 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах "Говь аргатай девелопмент" ХХК-ийн ашигт малтмал олборлон баяжуулах 34'020 шоометр, ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ 1'575 шоометр, тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад 54.0 шоометр, зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус 1918.00 шоометр нийт 37'567.00 шоометр усыг 1 жилийн хугацаагаар ашиглахыг зөвшөөрсүгэй.


2. "Говь аргатай девелопмент" ХХК-ийн ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавин ажиллахыг Газрын доорх усны нөөц ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Сарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Монгол Улсын "Улсын тэмдэгтийн хураамжийн тухай" хуулийн 21.1.20-д заасны дагуу ус ашиглах зөвшөөрлийн хураамжийг Баянжаргалан сумын Төрийн сан банкны дансанд тушаах, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг Дундговь аймгийн төсөвт гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлэхийг "Говь аргатай девелопмент" ХХК-ийн захирал /Б.Болдбаатар/-д үүрэг болгосугай.

4. Усны тухай хуулийн 30.1 дэх заалтын дагуу ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны ашиглах боломжит нөөцийн хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэхгүй байх болон Усны тухай хуулийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг 2025 оны 12-р сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг "Говь аргатай девелопмент" ХХК-ийн захирал /Б.Болдбаатар/-д даалгасугай.

ДАРГА  Б.ОТГОНСҮРЭН

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



2025 оны 09 сарын 26-ны өдөр

Дугаар- 24

Чойр хот

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу “Усны Газар”-ын гаргасан 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн Е-2508-000045 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны даргын олгосон 2025 оны 09-р сарын 23-ны өдрийн А/32 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Умард говийн гүвээт-Халхын дундад талын Сав газрын захиргааны Усны нөөцийн нэгдсэн менежмент, төлөвлөлт, олон нийт, сургалт, хариуцсан мэргэжилтэн З.Отгончимэг

Ус ашиглагчийг төлөөлж: Дундговь аймаг, Баянжаргалан сум, 3-р баг Аргатай, Дөшийн 1-1 тоот, 9019097895 улсын бүртгэлийн дугаар 3433668 регистрийн дугаартай “Говь аргатай девелопмент” ХХК -ийн менежер Д.Ууганбаатар нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт. Баяжуулах үйлдвэр нь 2025 онд “Улаан хад кристал майнинг” ХХК-ийн хайлуур жоншны MV-021094 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ордоос 25%-ийн агуулгатай 40.0 мян.тн хайлуур жонш худалдан авахаар төлөвлөсөн.

Тэр бум модны үндэсний хөдөлгөөний хүрээнд 100 ш мод тарихаар төлөвлөсөн.

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: 37'567 м³/жил

2.2.1. Ашигт малтмал олборлон баяжуулах: 34'020 м³/жил

2.2.2. Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл,

үйлчилгээнд ашиглах усны хэмжээ: 1'575 м³/жил

2.2.3. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад: 54.0 м³/жил

2.2.4. Зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус: : 1'918 м³/жил

2.3. Усны чанар, найрлага: Гидрогеологийн энгийн нөхцөлтэй усны химийн найрлагын хувьд эрдэсжилт өндөртэй 1-3г/л усны нь химийн найрлагаараа гидрокарбонат, кальци, магни зонхилсон байна.

2.4. Усны эх үүсвэр: Ажилчдын унд ахуйн ус болон техногийн усыг тус бүр 10 л/сек ундаргатай 2 худгаас хангана.

2.4.1. Байршил:

2.4.2. Солбицол:

№	Худгийн нэр	Уртраг	Өргөрөг
1	1-р худаг	х-108 01 39.3	у-45 44 49.4
2	2-р худаг	х-108 01 36.6	у-44 44 46.3

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

2.4.3.Барилга байгууламж: Суурийг нь бетондож, ус үл нэвтрүүлэх түрхлэгээр бүрэн түрхэж хийсэн 800 м³ багтаамжтай усан сантай.

2.4.4.Тоног төхөөрөмжийн нэр, марк: Мэдээлэл байхгүй

2.5. Хаягдал ус:Хаягдал бохир усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулдаг.

Хаях цэгийн байршил:Үйлдвэрийн талбайд

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

Жинлэгдэх бодис, кг:.....

Органик бодис, кг:.....

Эрдэс бодис, кг:.....

Хүнд металл, кг:.....

Аюултай бохирдуулах бодис, гр:.....

2.7. Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

2.9. Усны тоолуур: Одкон маркийн LXLG-80 мм голчтой 2 ш тоолууртай.

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Ашигт малтмал олборлон баяжуулах 34'020 м³/жил, ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ 1'575 м³/жил, тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад 54.0 м³/жил, зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус 1918.00 м³/жил газрын доорх усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор баталсан Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолд заасан газрын доорх усны нөөц ашигласны төлбөрийг урьдчилсан байдлаар тооцвол:

Хайлуур жонш баяжуулах зориулалтаар ашиглах газрын доорх усны төлбөр:

$$1\text{м}^3 \text{ газрын доорх усны үнэ } 3'700\text{төг/м}^3 \times 0.35 \times 1.6 = 2'072\text{төг/м}^3$$

- 3'700төг/м³- Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:

- (35%)- Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 7(а) газрын доорх ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээ. Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 416 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон/

- 1.6- Ашигт малтмал олборлох, баяжуулах зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$34'020 \text{ м}^3/\text{жил} \times 2'072 \text{ төг/м}^3 = 70'489'440 \text{ төг}$$

Жич:Усны газрын газрын ус ашиглуулах дүгнэлтэд Ашигт малтмал олборлох, баяжуулах зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр 1.8 авсан байсныг 1.6 болгож засаж тооцов.

Ашиг олох зориулалтаар ашиглах газрын доорх усны нөөц ашигласны төлбөр

$$1\text{м}^3 \text{ усны нөөц ашигласны төлбөр: } 3700\text{төг/м}^3 \times 0.15 \times 0.16 = 88.8 \text{ төг/м}^3$$

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

- 3700 төг/м³ – Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи, эдийн засгийн суурь үнэлгээ
- (15%) - Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 10-д заасан хувь, хэмжээ.
- 0.16 - Бусад, ашиг олох зориулалтаар үйлдвэрлэл үйлчилгээнд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр

$$1'575 \text{ м}^3/\text{жил} \times 88.8 \text{ төг} = 139'860 \text{ төг}$$

Зам талбайн тоосжилт дарахад ашиглах газрын доорх усны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ } 3'700 \text{ төг/м}^3 \times 0.2 \times 0.25 = 185.0 \text{ төг/м}^3$$

- 3'700 төг/м³ Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:
- (20%) - Засгийн газрын 326-р тогтоолын 4-т заасан авто замын зориулалтаар тооцох газрын доорх усны хувь хэмжээ.
- 0.25- Авто замын зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$1918 \text{ м}^3/\text{жил} \times 185.0 \text{ төг/м}^3 = 354'830 \text{ төг}$$

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад ашиглах газрын доорх усны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ } 3'700 \text{ төг/м}^3 \times 0.1 \times 0.2 = 74.0 \text{ төг/м}^3$$

- 3'700 төг/м³ - Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:
- (10%) - Засгийн газрын 326-р тогтоолын 9 заасан нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн усалгаанд тооцох газрын доорх усны хувь хэмжээ.
- 0.2- Ногоон байгууламжийн усалгаанд газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$54.0 \text{ м}^3/\text{жил} \times 74.0 \text{ төг/м}^3 = 3'996 \text{ төг}$$

Нийт төлбөр: 70'489'440 төг + 139'860 төг + 354'830 төг + 3'996 төг = 70'988'126 төгрөг

/далан сая есөн зуун наян найман мянга нэг зуун хорин зургаан төгрөг/

Ашигт малтмал олборлон баяжуулахад ашиглах усны төлбөр 70'988'126 төгрөг /далан сая есөн зуун наян найман мянга нэг зуун хорин зургаан төгрөг/-ийг Дундговь аймгийн Төрийн сан банкны 100080000944/ тоот дансанд төвлөрүүлнэ.

Жич: Газрын доорх ус ашигласны төлбөрийг усны эх үүсвэрт байрлуулсан баталгаажсан усны тоолуурын заалтаар төлбөрийг тооцуулан ажиллах шаардлагатай.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Татварын байцаагчийг байлцуулан сар бүрийн 20-25-ны дотор авч, дараа сарын 10-ны дотор төлнө.

Гурав. Талуудын эрх үүрэг

3.1. Ус ашиглуулагч нь “Усны тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.1.9, 17.1.10 дахь заалтын дагуу эрх эдэлнэ.

3.2. Ус ашиглагч нь дараах үүрэгтэй:

3.2.1. Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтын дагуу ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх;

3.2.2. Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтын дагуу ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах;

3.2.3. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон мэдээг сав газрын захиргаанд гаргаж өгнө.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

3.2.4. Ажилчдын ундны усыг “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS0900:2018 стандартын шаардлагад нийцсэн усаар хангаж, улиралд 1 удаа байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг Сав газрын захиргаанд ирүүлэх;

3.2.4. Ус ашиглалтын байдалтай холбоотой асуудлыг тухай бүрт нь мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд Сав газрын захиргааны холбогдох мэргэжилтнийг дуудаж газар дээр нь шийдвэрлэж байх.

3.2.5. Үйл ажиллагаа зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед Сав газрын захиргаа болон холбогдох төрийн байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж ирүүлэх;

3.2.6. Тухайн сумын татварын болон байгаль орчны хяналтын улсын байцаагчдыг тус тус байлцуулан тоолуурын заалтыг сар бүрийн эхний болон эцсийн заалтыг акт, зургаар баталгаажуулалт хийж 1 хувийг Сав газрын захиргаанд ирүүлэх;

3.2.7. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглох;

3.2.8. Голын хамгаалалтын бүсэд хөрс хуулалт, олборлолт явуулахыг хориглох;

3.2.9. Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа голыг хамгаалах, хөв цөөрөм байгуулах, татмын ойжуулалт хийх гэх мэт арга хэмжээ авч ажиллах;

3.2.10. Улирал бүр 2-оос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариу дүнг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор Усны газар болон Сав газрын захиргаанд ирүүлэх;

3.2.11. Хаягдал бохир усыг стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, цэвэрлэсэн усаа ногоон байгууламжийн усалгаанд ашиглах;

3.2.12. “Усны тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.2.3, 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалтуудын дагуу аж ахуй нэгж байгууллага нь газрын доорх усны дотоод хяналтын цэгийг байгуулна.

3.2.13. Гэрээнд заасан хэмжээнээс илүү ус ашигласан тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу усны нөөц ашигласны төлбөрийг шатлан өсгөж тооцно.

3.2.14. Усыг гэрээнд зааснаас бусад зориулалтаар, буюу хэмжээнээс хэтрүүлэн ашигласнаа нуун дарагдуулсан, зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, усны төлбөр төлөхөөс зайлсхийсэн болон төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд “Зөрчлийн тухай” хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3.2.15 Усны тухай хуулийн 30.1.2-т заасны дагуу усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах үүрэгтэй тул хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд ус ашиглуулах дүгнэлт гаргахгүй байхыг анхаарах.

3.2.16 Хаягдлын сангийн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, Усны газраар дүгнэлт гаргуулах.

3.2.17 Усны эх үүсвэр өөрчлөгдсөн тохиолдолд ус ашиглуулах боломжит нөөцийн дүгнэлтийг шинэчлэн гаргуулахыг анхаарах.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Ус ашиглуулагч нь 2025 оны 12 дугаар сарын 25-ны дотор ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд, нэмэлт өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

4.5. Гэрээг Усны тухай хуулийн 17.1.9, 29.3 дахь заалтууд болон дор дурьдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцална.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.

4.5.2. Аль нэг тал нь татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны Усны нөөцийн нэгдсэн менежмент, төлөвлөлт, олон нийт, сургалт хариуцсан мэргэжилтэн

...../З.Отгончимэг/

Хаяг: Монгол улс, Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 2-р баг

Харилцах утас: 7054-3599, 99308793

Ус ашиглагчийг төлөөлж:

“Говь аргатай девелопмент” ХХК-ийн менежер

...../Д.Ууганбаатар/

Дундговь аймаг, Баянжаргалан сум, 3-р баг Аргатай, Дөшийн 1-1 тоот

Харилцах утас: 8811-3273, 8911-8690

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 09 -р сарын 19 -ны өдөр

Дугаар Е-2508-000045

Улаанбаатар хот Утас:
265528, 265578

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Оноосон нэр: Говь аргатай девелопмент ГХО-тай ХХК
 Улсын бүртгэлийн дугаар:
 Регистрийн дугаар: **3433668**
 Захирал: **Болдбаатар**
 Холбоо барих дугаар: **88113273**
 Факс :
 И-мэйл хаяг :

2.Төслийн нэр байршил

Төслийн нэр: Хайлуур жоншны хүдрийг гравитацийн аргаар баяжуулах үйлдвэр
 Байршил: Дундговь, Баянжаргалан, 3-р баг, Аргатай
 Харьяалагдах сав газар: Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар
 Хамаарах салбар: Уул уурхай
 Төслийн дэлгэрэнгүй: "Говь-Аргатай девелопмент" ХХК -ийн Хайлуур жоншны хүдрийг гравитацийн аргаар баяжуулах төсөл нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын 1-р багт Баянжаргалан сумын төвөөс зүүн урд зүгт 2.5 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 300 км, Говьсүмбэр аймгийн Чойр хотоос баруун урагш шулуунаар 80 км-т байрлана. Төсөл нь 2025 онд "Улаан хад кристал майнинг" ХХК-ийн MV-021094 дугаар ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй жоншны ордоос 25 %-ийн агуулгатай 40.00 мян.тонн хүдэр худалдан авч, боловсруулан, 10.00 мян.тнн хайлуур жонш гарган авахаар төлөвлөсөн.

3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

Говь аргатай девелопмент

4. Ажиллах горим, хүчин чадал

Үргэлжлэх хугацаа	Ажиллах горим	Жилд ажиллах хоног	Хоногт ажиллах ажилчидын тоо	Хоногт ажиллах цаг
5	1 ээлжээр	300	35	10

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
Ашигт малтмал олборлон баяжуулахад ашиглах усны хэмжээ	40000.0	тонн	Баяжуулах үйлдвэрийн 2025 оны батлагдсан төлөвлөгөөний маягт 3-т нийт 40.00 мян.тонн хүдэр боловсруулж 10.00 мян.тонн хайлуур жонш гарган авахаар төлөвлөсөн. Төслийн БОННУ-ний 31-р хуудсанд технологид ашиглах нийт усны 75.7 %-ийг эргэлтийн усан хангамжаар хангах бөгөөд 24.3 %-ийг нөхөн сэлбэлтээр авч ашиглана гэсэн.
"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад ашиглах усны хэмжээ	100.0	ш	Төслийн 2025 оны батлагдсан төлөвлөгөөний маягт 10-т 100ш мод тарихаар төлөвлөсөн.
Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	7672.0	м2	Төслийн усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд нийт 7672 м2 зам, талбайн тоосжилтыг 125 удаа дарахаар төлөвлөсөн.
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	35.0	хоногт 1 хүн	Төслийн 2025 оны батлагдсан төлөвлөгөөнд нийт 35 хүн, 300 хоног ажиллана гэсэн.

6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

Эх үүсвэр	Зориулалт	Усны нөөц (л)	Усны нөөц (м3)	Тайлбар
Гүний худаг	Унд ахуй	5.0	432.0	Усны газрын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 131 дугаартай усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах 829.3 м3/хон усны хэрэглээг 10.0 л/сек (864.0 м3/хон) нийлбэр ундаргатай өрөмдмөл худгаас хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй гэсэн. Худгийн солбицол: 108°01'39.3", 45°44'49.4"
Гүний худаг	Технологийн хэрэгцээнд	5.0	432.0	Худгийн солбицол: 108°01'36.6", 44°44'46.3"

7. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ :

Газар дэлхий ХХК

Холбоо барих :

7012 4424

Нэмэлт мэдээлэл:

8. Усны барилга байгууламжууд

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Барилга байгууламж	Хүчин чадал (м3)	Хэмжээ хийц
Усан сан	800.0	Суурийг бетондож, ус үл нэвтрүүлэх түрхлэгээр бүрэн түрхэж хийсэн.

9. Дамжуулах байгууламж

Хаанаас (эхлэх цэг)	Хаана хүртэл (төгсгөлийн цэг)	Шугамын голч, мм	Дамжуулах шугамын урт, м
	Баяжуулах үйлдвэр	200	15

10. Онцгой нөхцөл

- Усны тухай хуулийн 30.1.2-т заасны дагуу усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах үүрэгтэй тул хуульд заасан үүргээ биелүүлэх, биелүүлээгүй тохиолдолд ус ашиглуулах дүгнэлт гаргахгүй болохыг анхаарах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах;
- Усан сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглоно;
- Голын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглоно;
- Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа голыг хамгаалах арга хэмжээ авах, хөв цөөрөм байгуулах, татмын ойжуулалт хийх;
- Хаягдлын сангийн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, Усны газраар дүгнэлт гаргуулах;
- Усны эх үүсвэр өөрчлөгдсөн тохиолдолд ус ашиглуулах боломжит нөөцийн дүгнэлтийг шинэчлэн гаргуулахыг анхаарах;
- Усны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх, шинэ технологи ашиглах, нөхөн сэлбэлтээр авах усны хэрэглээг бууруулах;

11. Усны зарцуулалт

Ажлын нэр	Тоо Хэмжээ	Хэмжих нэгж	Усны хэрэглээ, м3 (Норм)	Гүйцэтгэх давтамж	Хэмжих нэгж	Нийт ашиглах усны хэмжээ, м3	Хөнгөлөх усны хэмжээ м3	Төлбөр тооцох усны хэмжээ м3
Ашигт малтмал олборлон баяжуулахад ашиглах усны хэмжээ	40000	тонн	3.5	1.0	Удаа	140,000.00	105,980.00	34,020.00
"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад ашиглах усны хэмжээ	100	ш	0.03	18.0	Удаа	54.00	0.00	54.00
Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	7672	м2	0.002	125.0	Хоног	1,918.00	0.00	1,918.00
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	35	хоногт 1 хүн	0.15	300.0	Хоног	1,575.00	0.00	1,575.00
Нийт						143,547.00	105,980.00	37,567.00

12. Урьдчилсан байдлаар тооцсон усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Ажлын нэр	Төлбөр тооцох усны хэмжээ, м3	Усны ангилал	Хөнгөлөх хувь хэмжээ, %	1 м3 усны үнэ	Усны нөөц ашигласны төлбөр, ₮	Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮	Төлбөл зохих дүн, ₮
Ашигт малтмал олборлон баяжуулахад ашиглах усны хэмжээ	34020.00	Газрын	0.0	2331.00	79,300,620.00	0.0	79,300,620.00
		доорх ус					
“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад ашиглах усны хэмжээ	54.00	Газрын	0.0	74.00	3,996.00	0.0	3,996.00
		доорх ус					
Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	1918.00	Газрын	0.0	185.00	354,830.00	0.0	354,830.00
		доорх ус					
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	1575.00	Газрын	0.0	88.80	139,860.00	0.0	139,860.00
		доорх ус					
Нийт	37,567.00				79,799,306.00		79,799,306.00

13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар

- Хурын усыг хуримтлуулах, ахуйн бохир усыг зохих стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж халдваргүйжүүлэн зам талбайн тоосжилт дарах, биологийн нөхөн сэргээлтэд эргүүлэн ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

14. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

- Ус ашиглуулах дүгнэлтийн онцгой нөхцөлийг хангаж ажиллаагүй тохиолдолд дараа оны ус ашиглуулах дүгнэлтийг гаргахгүй болохыг анхаарах;
- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус ашиглах шугам хоолой бүрд тоолуур суурилуулж, баталгаажуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 26.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх;
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны нөөц ашигласны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах;
- Усны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх, шинэ технологи ашиглах, нөхөн сэлбэлтээр авах усны хэрэглээг бууруулах;
- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа жилийн эхний улиралд багтаан гаргуулах;
- Үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед Сав газрын захиргаа болон холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж ирүүлэх;
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2025 оны 12 дугаар сарын 20-ны дотор Усны газарт office@water.gov.mn цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах;

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Боловсруулсан:

УС АШИГЛАЛТЫН ХЭЛТЭС

О.Оюунгэрэл

Боловсруулсан огноо:

2025.09.10



Бойгууллагын нэр: Усны газар
Газар хэлтэс: Удирдлага
Албан тушаал: Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Овог нэр: Энээмъядар Батбаяр
Зурсан огноо: 2025.09.19 16:36:59

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2025 он 06 сарын 10 өдөр

№

Баянжаргалан сум

Нэг . Нийтлэг үндэслэл

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17-р зүйлийн 2,6 дахь заалт , Хог хаягдлын тухай хуулийн 8.4, 9.2, 20.1, 20.2 дугаар зүйл, Сумын ИТХ-ийн 2019 оны 05 тоот тогтоолыг үндэслэлээ.

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

Хоёр. Гэрээ байгуулагч талууд

Нэг талаас Дундговь аймгийн Баянжаргалан сумын ЗДТГ-ыг төлөөлж Байгаль орчны мэргэжилтэн Хүрэлхүү овогтой Сарангэрэл Нөгөө талаас “Говь Аргатай девеломент ” ХХК-ний жоншний баяжуулах уурхай Дундговь /аймаг/-ийн Баянжаргалан /сум/-ын 3-р баг Аргатай улсын бүртгэлийн гэрчилгээ тоот 3433668 регистрийн дугаартай “Говь Аргатай девеломент” ХХК-ийн баяжуулах үйлдвэр захирал Батцоодол овогтой Болдбаатар- нар харилцан тохиролцож 2025 оны 06 сарын 10 -ны өдрөөс 2026 оны 06 сарын 10 -ийг хүртэл энэхүү гэрээг байгуулав.

Гурав. Төлбөр тооцсон байдал

Баянжаргалан сумын 2019 оны 12 дугаар сарын 19-ны ИТХ-ын 05 тогтоолд заасны дагуу сард 150000 төгрөгөөр тооцов.

Төлбөрийг Төрийн сан банкны 100080500947 тоот дансанд тушаана. / ДУ.А Хог хаягдлын хураамж/

Сарын төлбөр 150000төгрөг /нэг зуун тавин мянган төгрөг/

Жилийн төлбөр 1.800,000 төгрөг / нэг сая найман зуун мянган төгрөг/

Дөрөв. Сумын ЗДТГ эрх

- 1 . Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах
- 2 . Иргэд аж ахуйн нэгж , байгууллагын хог хаягдал гаргасны төлбөрийг төвлөрүүлэх
- 3 . Иргэд аж ахуйн нэгж , байгууллагын хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих
- 4 . Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэнд хяналт тавих.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Тав. Иргэн ААН байгууллагын эрх үүрэг

1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх.
2. ААНэгж байгууллага нь хог хаягдал гаргасан төлбөрөө улирал бүрийн сүүл сарын 15-ны дотор гэрээнд зааснаар Дундговь аймгийн Баянжаргалан сумын татварын байцаагчтай холбогдож хог хаягдлын төлбөрөө төлөх.
3. Хог хаягдлыг ангилан ялгаж байх
4. Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлын талаархи дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах.
5. Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг сумын захиргаанд мэдээлж байх.
6. Хог хаягдлыг ангилан хаях талаар мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлэх, сургалт сурталчилгаа явуулах, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах.
7. Оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох.
8. Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага албан тушаалтнаас шаардах.
9. Үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээллэх.
10. Дундговь аймгийн Баянжаргалан сумын татварын байцаагчтай холбогдож хог хаягдлын төлбөрөө төлөх.
11. Сумын төвийн нэгтсэн хог хаягдлын талбай дээр хогоо асгахдаа бүртгэл хийх, нэгтсэн хогийн цэгийг талбайг 2 удаа шууж цэвэрлэх.

Зургаа. Гэрээний хариуцлага

1. Аж Ахуй нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог хаягдал хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохирлыг арилгах шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.
2. Аж Ахуй нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Дундговь аймаг
Баянжаргалан
ЗДТГазар БОМЭрэгжилтэн
Х.Сарангэрэл
Утас 88032429

“Говь Аргатай девелопмент” ХХК Баяжуулах үйлдвэр
Захирал

Б. Болдбаатар
Утас 88113273



Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



МОНГОЛ УЛСЫН АЖ ҮЙЛДВЭР,
ЭДЭС БАЙГУУЛГАНЫ ЯАМ
ХХК-ЫН КОМИССЫН АКТ

Төрийн захиргаа /Хүндэтгэл/

Төрийн захиргаа /Хүндэтгэл/

Төрийн захиргаа /Хүндэтгэл/

Говь-Аргатай девелопмент ХХК-ийн
зохиомол буй жоншны баяжуулах үйлдвэрийн
ажиллагаанд хүлээн авах журам

НЭГ. ЕРӨНӨМӨЙ ЭГНЭЛ

- 1.1. Гурхай, уулсан үйлдвэрийн нэр, байршил, хүчин чадал, ашигт малтмалын төрөл, хөрөнгө оруулалт, ашиглагчдын тоо
 - Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших Говь-Аргатай девелопмент ХХК-ийн жоншны баяжуулах үйлдвэр;
 - Хүчин чадал: 40.0 млн.тс;
 - Ажлын байр: Нийт 35 хон /уундас гадарг ажилчин – 3/;
 - Хөрөнгө оруулалтын хэмжээ: Төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 2.5 тэрбум төгрөг;
 - Ажиллагаа эхлэх жил: 2024;
 - Үлс, орон нутгийн төсөвт: Төслийн зулцаанд 5.4 тэрбум төгрөг.
- 1.2. Зохиомол байгууллага, аж ахуйн нэгж: Говь-Аргатай девелопмент ХХК
- 1.3. Төслийн төлөө, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байгууллага, аж ахуйн нэгжийн нэр: "Бизнесгэзүр эрдэнэ" ХХК
- 1.4. "Журам батлах тухай" Уул гурхай, хүнд үйлдвэрийн сайрын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/202 дугаар туслаган өндүртэй хяналтанд батлагдсан "Уулсай, уулсан болон баяжуулах үйлдвэрийг ажиллагаанд оруулах ашиг журм"-ийн 1 дугаар зүйлийн 1.5 дугаар зэмлэгийг үндэслэн Уул гурхай, хүнд үйлдвэрийн жоншны Төрийн нэрийн бичгийн даргын үндэслэлээр томилгоорон Улсын өмчөө Говь-Аргатай девелопмент ХХК-ийн зохиомол буй жоншны баяжуулах үйлдвэрийг ажиллагаанд оруулах ашиг тухай тусгай зөвшөөрөл зохиомолын 2024 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн 2402 дугаар албан ёслалтын дагуу 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр тус компанийн үйлдвэрт ажиллах, хэлбэрдэх зүүгь тогтоомжийн дагуу үйл ажиллагаа жуулахад шаардлагатай бүрдүүлбэл зөвч бичиг баримтын бүрдэлтэй тэнцдэг.

ХОЁР. АЖИЛДЭГ

- 2.1. Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших Говь-Аргатай девелопмент ХХК-ийн жоншны баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа, хэлбэрдэх зүүгь тогтоомжийн дагуу үйл ажиллагаа жуулахад шаардлагатай бүрдүүлбэл зөвч

1508 17 0114

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



бичиг баримтын бүрдэлтэй танилцаад "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах" Улсын комиссоос **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

2.1.1. "Говь-Аргатай девелопмент" ХХК-ийн баяжуулах үйлдвэр нь Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/303 дугаар тушаалаар баталсан журмын 2.2-т заасны дагуу "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээлгэн өгөх бэлтгэл ажил"-ыг хангасан гэж үзэв.

2.1.2. Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлүүлэхийг "Говь-Аргатай девелопмент" ХХК /гүйцэтгэх захирал Б.Болдбаатар/-д зөвшөөрөв.

2.2. Улсын комиссоос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг "Говь-Аргатай девелопмент" ХХК-ийн удирдлагад чиглэл болгов.

ГУРАВ. УЛСЫН КОМИССЫН ЗӨВЛӨМЖ

- 3.1. Ашигт малтмалын тухай хуульд заасан ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлэн мөрдлөг болгон ажиллах;
- 3.2. Үйлдвэрийн ажлын байрны онцлогт тохирсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журам заавруудыг боловсруулж, мөрдлөг болгон ажиллаж, хөдөлмөр, хамгааллын өдөр тутмын болон сар, улирлын давтан зааварчилгааг өгч ажиллах;
- 3.3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2020 оны А/155, А/132 дугаартай "Ашигт малтмалын баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах;
- 3.4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/205 дугаартай тушаалаар баталсан "Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах;
- 3.5. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дахь хэсэг Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын дагуу дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтныг томилон ажиллуулах, *Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг батлуулан үйл ажиллагаандаа мөрдөх, Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлж* ажиллах;
- 3.6. Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн тогтоосон түвшний хэм хэмжээг хэтрүүлж үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулахгүй байх талаар байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах;
- 3.7. Орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран ажиллах гэрээг байгуулж, орон нутгаас ажилтан албан хаагчдыг авч ажиллуулах;
- 3.8. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймаг, сумын нутагт мод тарих, арчлах, уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган, биелэлтийг ханган ажиллах;
- 3.9. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллах;
- 3.10. Аюулгүй ажиллагааны зааварчилгааны дэвтрийн хөтөлтийг сайжруулах;

АЖ ҮЙЛДВЭР ЭРДЭС
БАЙЛГИЙН ЯАМ
УУРХАЙ, УУЛЫН БО:
БЯЖУУЛАХ ҮЙЛДВЭ:
АШИГЛАЛТАД ХҮЛЭ
АВАХ УЛСЫН КОМ:
СБТ-201957-5024

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

- 3.11. Ажлын байрны онцлогт тохирсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журам, зааврыг боловсруулж мөрдөх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны давтан зааварчилгааг тухай бүр өгч хэвших;
- 3.12. Үйлдвэрийн орчимд тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, орон нутгийн иргэд зорчихоос сэргийлэх;
- 3.13. Хуримтлалын усан санд хаалт хашалт хийх;
- 3.14. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж дуусгах;
- 3.15. Үйлдвэр доторх шатыг стандартын дагуу барьж байгуулах;
- 3.16. Хүдэр бэлтгэх хэсгийн бункерт сэрээт дохио байршуулах;
- 3.17. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжид гэрчилгээ гаргуулах;
- 3.18. Няналтын удирдлагын Хятад бичгүүдийг Монгол хэл дээр орчуулж тавих;
- 3.19. Орон нутгаас замын трасс батлуулах;
- 3.20. Тэмдэг, тэмдэглэгээг нэмж байршуулах;
- 3.21. Шатахуун түгээх станцын зам талбайн орц, гарц дээр 0.2 метрээс багагүй өндөртэй өндөрлөгөө, байгууллагын дотоод хэрэгцээний шатахуун түгээх станц, түүний технологийн тоног төхөөрөмжөөс зэргэлдээ орших барилга, байгууламж хүртэл хамгийн бага зайг 40, хөдөлгөөнт шатахуун түгээх станцад тавигдах шаардлагыг 80м зайд байршуулах;
- 3.22. Тусгай эрх бүхий байгууллагатай аюултай хог хаягдлын гэрээг байгуулах;
- 3.23. Үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах зэрэг болно.

КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН:

Дарга:

Нарийн бичгийн дарга:

Гишүүд



Б.Дашбал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ахлах шинжээч;

С.Пүрэвжал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны мэргэжилтэн;

Д.Пүрэвбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Салбарын хяналтын газрын Улсын ахлах байцаагч;


О.Амарсанаа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын Байгаль орчны үнэлгээ аудитын хэлтсийн ахлах шинжээч;

Г.Хишигдаваа, Дундговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга;


Д.Маасүрэн, Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул, ашиглалтын газрын Уул уурхайн хэлтсийн мэргэжилтэн.




Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан




Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан




Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан




Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 15. дугаар албан бичгийн хавсралт



УС АШИГЛАХ ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ

№04

Ус ашиглах гэрээний дугаар, гэрээ байгуулсан он сар өдөр	2025.09.26-ний өдөр Дугаар - 24
Төслийн нэр	Жоншны хүдрийг гравитацийн аргаар баяжуулах
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	Говь Аргатай девелопмент ХХК
Регистрийн дугаар	3433668
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-012412
Төслийн байршил	Дундговь аймгийн Баянжаргалан сум
Гэрээ дүгнэсэн он сар өдөр	2026.01.12

ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Гэрээний гол нөхцөл	80%
1	1. Усны эх үүсвэр - Унд, ахуйн (Гүний худаг, зөврөөр) - Технологи (Шүүрлийн ус, гадаргын ус, газрын доорх ус) - Зам талбайна тоосжилт - Ногоон байгууламжийн усалгаа	Ажилчдын унд ахуйн ус болон технологийн усыг тус бүр 5 л/сек ундаргатай 2 худгаас хангана.
2	2. Ашиглах усны хэмжээ (м ³) 2.1.1. унд ахуй 2.1.2. ашигт малтмал олборлон баяжуулахад ашиглах ус 2.1.3. зам талбайн тоосжилт 2.1.4. ногоон байгууламжийн усалгаа Нийт	2.2. Нийт ашиглах усны хэмжээ: 37'567 м ³ /жил 2.2.1. Ашигт малтмал олборлон баяжуулах: 34'020 м ³ /жил 2.2.2. Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ: 1'575 м ³ /жил 2.2.3. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад: 54.0 м ³ /жил 2.2.4. Зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус: : 1'918 м ³ /жил
3	3.1. Усны чанар найрлага	Гидрогеологийн энгийн нөхцөлтэй усны химийн найрлагын хувьд эрдэсжилт өндөртэй 1-3г/л усны нь химийн найрлагаараа гидрокарбонат, кальци, магни зонхилсон байна. Ланд овнер ХХК-ний Хөрс, усны шинжилгээний лаборторид 2025.09.02-нд 1 удаа усны химийн ерөнхий шинжилгээний үзүүлэлтээр шинжилгээ өгсөн. Улиралд 4 удаа шинжилгээ өгөх заалтын хэрэгжилт хангагдаагүй.
4	4.1. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлэх арга, хөрөнгийн хэмжээг төлөвлөж ирүүлэх.	Тайланд мэдээлэл ирүүлээгүй.
5	5.1. Усны тоолуур	Дундговь Ус ОНӨААТҮГ-аар LXLС-80 маркийн тоолуур суурилуулсан.

CamScanner ашиглан сканнердсан

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

<p>6.1. Усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ (мян.төг)</p> <p>6.1.1. унд ахуй</p> <p>6.1.2. ашигт малтмал олборлон баяжуулахад</p> <p>6.1.3. зам талбайн тоосжилт дарахад</p> <p>Нийт</p>	<p>2025 онд баяжуулах үйлдвэр нь “Улаан хад кристал майнинг” ХХК-ийн хайлуур жоншны MV-021094 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ордоос 25%-ийн агуулгатай 40.0 мян.тн хүдэр худалдан авахаар төлөвлөсөн боловч өмнө онд авсан 5714.3 тн хүдрийг баяжуулсан.</p> <ul style="list-style-type: none"> - 5714.3 тн x 3.5 x 24.3% = 4860 м³/жил - Тоолуурын заалт 5'024 м³/жил <p>Усны төлбөр</p> <ul style="list-style-type: none"> - 5'024 м³/жил x 2'072 төг/м³ = 10'409'728 төгрөг - 1'575 м³/жил x 88.8 төг = 139'860 төгрөг - 1918 м³/жил x 185.0 төг/м³ = 354'830 төгрөг - 54.0 м³/жил x 74.0 төг/м³ = 3'996 төгрөг <p>Нийт төлбөр: 10'409'728 төг + 139'860 төг + 354'830 төг + 3'996 төг = 10'908'414 төгрөг</p>
<p>7 7.1. Тухайн жилийн ус ашиглалтын тайланг хүлээн авах.</p>	<p>2025 оны ус ашиглалтын тайланг 2025.12.17-ны өдөр ирүүлсэн.</p>

Дүгнэлт:

- Ашигласан усны төлбөрийг 2025.11.25-ний өдөр Дундговь аймгийн дансанд бүрэн төлсөн байна. Тайланд баримтыг ирүүлсэн.
- Цаашид ус ашиглах гэрээнд илүү ашигласан усны төлбөрийг Засгийн газрын 2018 оны 12 сарын 26-ны өдрийн 391 дугаар тогтоол “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам”-ын дагуу тооцон ажиллахыг анхаарах.
- Усны шинжилгээг байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторт сорьцыг өгч шинжлүүлэх, унд ахуйн усыг улиралд нэг удаа, бохир усны сорьцыг улиралд 2-оос доошгүй удаа өгсөн байх шаардлагыг хангаж ажиллах.
- Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлэх арга, хөрөнгийн хэмжээг төлөвлөж ирүүлээгүй цаашид тайланд тусгаж ирүүлэх шаардлагатай.

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

УС АШИГЛУУЛАГЧ:

УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


/Б.САРАНТУЯА/

УУЛ УУРХАЙ, ЭРЧИМ ХҮЧНИЙ УС АШИГЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН


/З.ОТГОНЧИМЭГ/


ХАЯГ: СУМБЭР МОНГОЛ УЛС, ГОВЬСУМБЭР АЙМАГ, СУМ, 2-Р БАГ, НОГООН ХӨГЖЛИЙН ТӨВ, 205 ТООТ
ХАРИЛЦАХ УТАС: 7054-3598, 7054-359

УС АШИГЛАГЧ:

“ГОВЬ АРГАТАЙ ДЕВЕЛОПМЕНТ” ХХК-НЫ ЕРӨНХИЙ ЗАХИРАГЧИЙН ТӨЛ


/Б.БОЛДБААТАР/

“ГОВЬ АРГАТАЙ ДЕВЕЛОПМЕНТ” ХХК-ИЙН МЕНЕЖЕР

 /Д.УУГАНБААТАР/

ХАЯГ: ДУНДГОВЬ АЙМАГ, БАЯНЖАРГАЛАН СУМ, 3-Р БАГ АРГАТАЙ, ДӨШИЙН 1-1 ТООТ
ХАРИЛЦАХ УТАС: 8811-3273, 8911-8690



Гүйлгээ амжилттай.

14,356,289.00 MNT

2025/11/05 16:20

Дансны үлдэгдэл



Хүлээн авагч

Ду.Ба Ус, рашааны төлбөр
MN03 0090 100080500944



Гүйлгээний утга


говь аргатай девелопмент усны
төлбөр

Загвар хадгалах

Дуусгах



Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



CamScanner ашиглан сканнердсан

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНД

Хүсэлт гаргах тухай

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргье

Манай компани нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын 3-р багийн нутагт гравитацийн аргаар жонш баяжуулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 онд түүхий эдийн олдоц муу байсан тул бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадаагүй болно

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б. БОЛДБААТАР

CamScanner ашиглан сканнердсан